

**"МОНГОЛ УЛСЫН 2018-2021 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР"-
ИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ ХАМААРАХ
ТӨСӨЛ,
АРГА ХЭМЖЭЭНИЙ 2020 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2021 оны 01 дүгээр сарын 28

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж гүйцэтгэв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг “Хөтөлбөр тодотгон батлах тухай” Засгийн газрын 2019 оны 290 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Монгол улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тодотголын шалгуур үзүүлэлт”-ийн дагуу гүйцэтгэв.

Энэхүү ажлын хүрээнд: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах төсөл, арга хэмжээний 2020 онд хэрэгжүүлсэн ажлын тайлан, тухайн ажлыг хариуцсан холбогдох ажилтнуудтай уулзаж ярилцлага хийх болон холбогдох статистик мэдээ, мэдээллийг ашиглав.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Монгол улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр” нь Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 290 дүгээр тогтоолоор батлагдсан.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт 2018-2021 онд дараах 7 төслийг хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнд:

№	Төслийн нэр	Хугацаа	Төсөвт өртөг /сая.төг/
Шилжин хэрэгжих төслүүд			
1	69.“Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих” төсөл	2018-2020 он	64,484.0
2	70.“Махны үйлдвэр, хорио цээрийн бүс бүхий цогцолбор байгууламж барих техникийн шинэчлэл хийх” төсөл	2019-2022 он	195,031.2
			10,264.8 /улсын төсвөөс/
3	71.“Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтэц байгуулах төсөл	2019-2021 он	388,932.5
4	72.Налайхын барилгын материал үйлдвэрлэл технологийн паркийн дэд бүтэц байгуулах” төсөл	2019-2021 он	94,349.0
5	73.“Дөрвөн улирлын хүлэмж” төсөл	2018-2020 он	101,000.0
6	74.“Алслагдсан орон нутагт сүүн бүтээгдэхүүнийг кластерын зарчмаар үйлдвэрлэж, импортыг орлож, экспортыг нэмэгдүүлэх” төсөл	2019-2020 он	117,000.0
	Дүн		971,061.5
Шинээр хэрэгжүүлэх төсөл			
1	132. Биокомбинат үйлдвэрийн өргөтгөл	2019-2022 он	52,640.0
	НИЙТ		1023,701.5

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТОВЧ ҮР ДҮН

“Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах төсөл, арга хэмжээний 2020 оны хэрэгжилт “Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 57.1 хувиар үнэлэгдлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ 2020 оны төсвийн гүйцэтгэл, шалгуур үзүүлэлт, хүрсэн үр дүнгээр дүгнэж үнэлсэн болно.

Хөтөлбөрт хүнс, хөдөө аж ахуйн салбарын чиглэлээр тусгагдсан 7 төслийн 2 нь 2018 оноос хэрэгжиж эхлэн 2020 онд дуусч байгаа, 5 нь 2019 оноос эхлэн хэрэгжихээр төлөвлөгдсөн тул хэрэгжилт болон санхүүжилтийн гүйцэтгэлд нь шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинтэй харьцуулж үнэллээ.

1. “Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих” төсөл

Засгийн газраас “Мах, сүүний анхдугаар аян” болон “Атрын гуравдугаар аян”-ыг зохион байгуулахтай холбоотойгоор БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр энэхүү төслийн хүрээнд үр тариа, тэжээл, хүнсний ногоо үйлдвэрлэлийн техникийг худалдан авахаар төлөвлөсөн.

Уг хөнгөлөлттэй зээл нь 20 жилийн хугацаатай, жилийн 2 хувийн хүүтэй, эхний 7 жилд үндсэн зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөх нөхцөлтэй юм.

Тайлант онд газар тариалан, тэжээл үйлдэрлэлд нэн хэрэгцээтэй байгаа 50-165 м.х-тэй трактор 180 ш, хадлангийн зориулалттай дунд оврын иж бүрдэл техник 40 ш, таримал тэжээл үйлдвэрлэлийн зориулалттай иж бүрдэл техник 20 ш, 9900 га талбайг услах хүчин чадалтай усалгааны тоног төхөөрөмж худалдан авах ажлыг бүрэн дуусгасан.

ХХААХҮ-ийн сайдын 2020 оны А-135, А-145 дугаар тушаалаар тариалан эрхлэгчдийг дэмжих зорилгоор трактор, техник тоног төхөөрөмжийн үнийг 50 хувиар хөнгөлж, заримыг нь шууд болон 20 хувийн урьдчилгаа төлбөртэйгээр борлуулсан.

Хөдөө аж ахуйг дэмжих сангаар дамжуулан 50-165 морины хүчтэй трактор 180 ш, хадлан бэлтгэх зориулалттай хадуур, тармуур, хаман боогчийн нийт 140 ш, дарш бэлтгэх зориулалттай үрлүүр, даршны комбайн, бордоо цацагч нийт 100 ш, 3041 га талбайг услах хүчин чадал бүхий 42 ш бороожуулагчийг зээлийн шалгуур хангасан иргэн, аж ахуйн нэгжид нийлүүлсэн.

Төслийн үр дүнд жилдээ 5.0 тэрбум төгрөгийн хадлан тэжээл, 4.0 тэрбум төгрөгийн таримал тэжээл, 1.5 тэрбум төгрөгийн үнэ бүхий хүнсний ногоо хураан авах боломжийг бүрдүүлсэн.

Нийт 450 хүний ажлын байр хадгалагдаж шинээр 150 хүний ажлын байр шинээр нэмэгдүүлсэн байна.

Трактор, техникүүдийг худалдан борлуулснаар 7300 га талбайн хөрс боловсруулах, 500 га талбайн 15.0 мянган тонн ногоон тэжээл хадаж хураах, 900 тонн төмс, хүнсний ногоо хураах боломжийг тариаланч, фермерүүдэд олгосон нь ихээхэн том дэмжлэг болсон байна.

Худалдан авсан техник, усалгааны тоног төхөөрөмжүүд нь олон улсын ISO стандартын шаардлага хангасан бөгөөд байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй юм байна.

Дүгнэлт: Төслийн хүрээнд 2018-2019 онд бүх нийлүүлэгдэх техник, тоног төхөөрөмжийг 100 хувь хүлээн авсан бөгөөд газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлээр техник, тоног төхөөрөмжүүдийг тариалан эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй үнээр 12 жилийн хугацаатай худалдан борлуулснаар 7300 га талбайн хөрс боловсруулах, 500 га талбайн 15.0 мянган тонн ногоон тэжээл хадаж хураах, 900 тонн төмс, хүнсний ногоо хураах боломжийг тариаланч, фермерүүдэд олгосон.

Усалгаатай тариалангийн талбайн хэмжээ 59.8 мянган га-аар нэмэгдсэн нь газар тариалангийн салбарт гарч байгаагүй том амжилт юм.

Төслийн хэрэгжилт “үр дүнтэй”-зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан тул “100” хувиар үнэлэв.

2. “Махны үйлдвэр, хорио цээрийн бүс бүхий цогцолбор байгууламж барих техникийн шинэчлэл хийх” төсөл

Төсөл нь 2019 оноос эхлэн хэрэгжихээр тусгагдсан. УИХ-ын 2017 оны “Олон улсын гэрээний тухай” хуулийн дагуу БНХАУ-ын Экспорт, Импортын банк хоорондын 1.0 тэрбум ам.долларын өртөгөөр хэрэгжүүлэх энэхүү төслийг 4 байршилд, шаардагдах төсөвт өртөгийн 95 хувийг зээлээр, үлдэх 5 хувийг төсвийн санхүүжилтээр хийхээр баталж, зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн жагсаалтад уг төслийг үргэлжлүүлэхээр Засгийн газрын 2017 оны 312 дугаар тогтоол гарч, хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

Төслийн хүрээнд: Малын гоц халдварт өвчингүй, тусгаарласан аж ахуй болон мал төхөөрөх, мах ангилж савлах үйлдвэр бүхий 4 цогцолбор /Ховд аймгийн Дарви сум, Баянхонгор, Архангай, Сүхбаатар аймагт/-ыг орон нутагт байгуулахаар төлөвлөсөн.

Одоогийн байдлаар улсын хэмжээнд бүртгэлтэй 74 мал төхөөрөх үйлдвэрүүд нь нядалгааны 90-120 хоногийн хугацаанд үйл ажиллагаа явуулж байна.

Энэхүү төсөл нь тусгаарласан аж ахуй бүхий тогтмол үйл ажиллагаатай мал төхөөрөх болон мах боловсруулах үйлдвэрийг байгуулах, үйлдвэрийн аргаар боловсруулсан махыг экспортлох, чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан махаар хүн амыг хангахад чиглэгдэх юм.

УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т уг төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тусгагдсан байна.

Дүгнэлт: БНХАУ-ын Машин механизм, аж үйлдвэрийн корпораци (Sinoconst)-ийн боловсруулсан ТЭЗҮ тус яамнаас гаргасан ажлын даалгаврын шаардлагыг зарим талаар хангаагүй учир төслийн ажил удааширч зогссон.

Иймд төслийн тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа тул биелэлтийг “30” хувиар үнэлэв.

3. “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтэц байгуулах” төсөл

Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа арьс шир, ноос ноолуур боловсруулах үйлдвэрүүд нь байгаль орчинд сөрөг нөлөөллийг бий болгож, тус орчны агаар, хөрс, усны бохирдлыг үүсгэгч үндсэн шалтгаан болж байна.

Иймд шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг хөгжүүлсэн, байгаль орчинд сөрөг нөлөө багатай, хөнгөн аж үйлдвэрүүдийн нэгдлийг бүтээн байгуулах зүй ёсны шаардлагын үүднээс уг төслийг хэрэгжүүлэх болсон.

Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн ҮТП-ийн дэд бүтцийг байгуулах ажлын хүрээнд өмнөх онуудад: Паркийн үерийн байгууламжийн ажлын зураг төсөл /9км/, цахилгаан хангамжийн ажлын зураг төсөл/110/35/10 дэд өртөө, технологийн усан хангамжийн ашиглалтын цооног гаргах ажил, барилга угсралтын үеийн цахилгаан хангамжийн ажлууд хийгдсэн.

Тайлант онд хөрөнгө оруулалтыг татах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: “Эмээлтийн “Хөнгөн үйлдвэрийн ҮТП-ийн төслийн магадлалын шинжилгээ, байгаль орчны үнэлгээ”-ний 400.0 сая төгрөг өмнөх оноос Нийслэлийн 2020 оны төсөвт шилжин батлагдаж, энэхүү ажлын гүйцэтгэгчээр Ди Ди Эй Жи ХХК шалгаран гэрээ байгуулан ажиллаж байна.

Цаашид тус паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад 479.1 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэсэн судалгаа, тооцоог гаргасан байх бөгөөд уг санхүүжилтийг гадаад орнууд, төсөл хөтөлбөрүүдэд хандсан ч шийдэлд хүрч чадахгүй өдийг хүрч ирсэн.

Эмээлтийн хөнгөн үйлдвэр, үйлдвэрлэл технологийн паркийн өнөөг хүртэл хийгдсэн ажил, санхүүжилтийн мэдээлэл

№	Хийгдсэн ажлууд	Хугацаа	Санхүүжилтийн дүн	Санхүүжилтийн эх үүсвэр	Гүйцэтгэлийн хувь
1	Эмээлт ҮТП-ийн ТЭЗҮ	2011	250 сая	Аж үйлдвэрийн яам	100%
2	Технологийн усан хангамжийн ашиглалтын цооног гаргах ажил	2014-2015	300 сая	Нийслэлийн төсөв	100%
3	Үерийн байгууламжийн ажлын зураг төсөв	2015	56.9 сая	Нийслэлийн төсөв	100%
4	Цахилгаан хангамжийн ажлын зураг төсөв /110кв/35кв/10кв дэд өртөө/	2015	57.7 сая	Нийслэлийн төсөв	100%
5	Технологийн усан хангамжийн ажлын зураг төсөв / 6км шугам усан сан/	2015	74.6 сая	Нийслэлийн төсөв	100%
6	Ундны усан хангамжийн ажлын зураг төсөв /14км усан сан/	2015	74.9 сая	Нийслэлийн төсөв	100%
7	Паркийн техник технологийн түвшний үнэлгээ	2015	23.2 сая	Нийслэлийн төсөв	100%
8	Барилга угсралтын үеийн цахилгаан хангамж	2015-2016	358.2 сая	Нийслэлийн төсөв	100%
9	Парк доторх инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөв / холбоо хангамж, цахилгаан, дулаан, ус/	2016	287.6 сая	Нийслэлийн төсөв	100%
10	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотгол	2017	120 сая	Нийслэлийн төсөв	100%
11	Авто замын зураг төсөл /18.18 км/	2018	188 сая	Нийслэлийн төсөв	100%
12	Төслийн магадлалын шинжилгээ, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ	2020-2021	400 сая	Нийслэлийн төсөв	70%
	Нийт санхүүжилт		2 тэрбум 191.1 сая.төг		

Засгийн газрын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 178 дугаар тогтоолоор Эмээлтийн "Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк"-ийн ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулах арга хэмжээ авах, паркийн дэд бүтцийг барьж байгуулах ажлыг эрчимжүүлэх Нийслэлийн засаг даргад даалгасан байна.

Дүгнэлт: Тухайн төслийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа тул уг төслийг “30” хувиар үнэлэв.

4. “Налайхын барилгын материал үйлдвэрлэл технологийн паркийн дэд бүтэц байгуулах” төсөл

Тус паркийн цэвэрлэх байгууламжийн төслийг "Нийслэлийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-д нэмэх тухай саналаа боловсруулан Нийслэлийн ЗДТГ-т хүргүүлснээр

НИТХТ-ийн 2020 оны 93 дугаар тогтоолоор тус жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулан батлуулсан.

Паркийн цахилгаан хангамжийн эхний ээлжийн бүтээн байгуулалт 110 кв-ын дэд станц, удирдлагын байрыг барих ажилд 3.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Нийслэлийн төсвөөс шийдвэрлэж, эхний ээлжийн бүтээн байгуулалт 110 кв-ын дэд станцын барилгын ажил дуусаж, тоног төхөөрөмжийг суулгах ажил хийгдэж байна.

Мөн паркийн цахилгаан хангамжийн 2 дугаар ээлжийн барилга угсралтын ажилд 2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Нийслэлийн төсвөөс шийдвэрлэж, ажлын гүйцэтгэл 70 хувьтай байна. Паркийн Налайх-Чойрын чиглэлийн төв замд холбох 4.64 км авто замын бүтээн байгуулалтын ажилд 2020 оны Нийслэлийн төсвөөс 5.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж, уг авто замын хучилтын ажил болон явган хүний замын тохижилтын ажил 100 хувь хийгдэж дууссан.

Паркийн үерийн хамгаалалтын барилга байгууламжийг барьж байгуулах ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэн 100 хувь дуусгаж, Улсын комисст хүлээлгэн өгөх саналыг хүргүүлсэн.

Засгийн газрын 2011 оны 104 дүгээр тогтоолын “Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу 4 иргэн, 1 аж ахуйн нэгжтэй үйл ажиллагаа явуулах гэрээ байгуулсан, 6 үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхээр газрын асуудлыг шийдвэрлэсэн.

Одоогийн байдлаар “Пийс стийл групп” ХХК, “Хужрын гол” ХХК-ууд үйлдвэрийн барилгыг барьж үйл ажиллагаагаа эхлүүлэхэд бэлэн болсон байна.

Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн өнөөг хүртэл хийгдсэн ажил, санхүүжилтийн мэдээлэл

№	Хийгдсэн ажлууд	Хугацаа	Санхүүжилт	Эх үүсвэр	Гүйцэтгэлийн хувь
1	Паркийн техник эдийн засгийн үндэслэл	2014	350 сая.төг	нийслэлийн төсөв	100%
2	10/10кВ-ийн дэд станц, 10кВ-ийн хуваарилах байгууламжийн ажлын зураг төсөл	2015	150 сая.төг	нийслэлийн төсөв	100%
3	Бүтээн байгуулалтын үеийн цахилгаан хангамжийн ажил	2015	458 сая.төг	нийслэлийн төсөв	100%
4	Усны нөөц тогтоох гидрогеологи ажил	2015	350 сая.төг	нийслэлийн төсөв	100%
5	Оффисын барилга /660 м2/	2015	672 сая.төг	нийслэлийн төсөв	100%
6	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө	2016	180 сая.төг	нийслэлийн төсөв	100%
7	Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ /5төсөл/	2016	180 сая.төг	нийслэлийн төсөв	100%
8	Сайжруулсан шороон зам /2км/	2016	120 сая.төг	нийслэлийн төсөв	100%
9	Гүний худаг /2 ш/	2016	44 сая.төг	нийслэлийн төсөв	100%
10	Паркийн дэд бүтцийн зураг төсвийн ажил	2017	1 тэрбум 128 сая.төг	БХБЯ	100%

11	Үерийн далангийн барилга байгууламж /1,65км/	2018	250 сая.төг	БХБЯ	100%
12	Авто замтай холбох 4.64 км авто зам /Бетон хучилттай 4 эгнээ/	2018	1 тэрбум 800 сая.төг	нийслэлийн төсөв	100%
13	Авто замтай холбох 4.64 км авто зам /Бетон хучилттай 4 эгнээ/	2019	1тэрбум 500сая.төг	нийслэлийн төсөв	100%
14	Үерийн далангийн ажил /1,65км/	2019	764 сая.төг	БХБЯ	100%
15	Паркийн үндсэн цахилгаан хангамжийн 110кв-ийн ЦДА ажлын зураг төслийн өөрчлөлт	2019	28.9 сая.төг	нийслэлийн төсөв	100%
16	Паркийн үндсэн цахилгаан хангамжийн эхний ээлжийн барилга угсралтын ажил/НД/	2020	3 тэрбум 186.3 сая.төг	нийслэлийн төсөв	100%
17	Паркийн цахилгаан хангамжийн 2 дугаар ээлжийн барилга угсралтын ажил/НД/	2020	2 тэрбум.төг	нийслэлийн төсөв	17.4%
19	Авто замтай холбох 4.64 км авто зам /Бетон хучилттай 4 эгнээ/	2020	5 тэрбум 513.7 сая.төг	нийслэлийн төсөв	100%
	Нийт олгогдсон санхүүжилт		18 тэрбум, 905.4 сая.төг		

Дүгнэлт: Паркийн цахилгаан хангамжийн 2 дугаар ээлжийн барилга угсралтын ажил 70 хувь, Налайх-Чойрын чиглэлийн авто замын хучилтын ажил болон явган хүний замын тохижилтын ажил 100 хувь хийгдэж дууссан, 6 аж ахуйн нэгж газрын асуудлаа шийдвэрлэсэн, 2 аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа эхлүүлсэн зэрэг үр дүн гарсан байна.

Тухайн төслийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн тул уг төслийг “50” хувиар үнэлэв.

5. “Дөрвөн улирлын хүлэмж” төсөл

Тайлант онд хүлэмжийн аж ахуй байгуулахад орон нутаг, гадаадын төсөл, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлснээр 14100 м2 талбай бүхий хүлэмжийг барьж байгуулсан. Үүнд:

- ЖДҮХС-аас Говь-Алтай, Орхон, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл аймаг, Улаанбаатар хотын 19 ААН-д хүлэмж байгуулахад 1.886.0 сая төгрөгийн зээл,
- АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй "Хоршоолсон хэлбэрээр хүнсний ногооны аж ахуйг хөгжүүлэх" төслийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Ерөө суманд 228.0 сая төгрөгийн өртгөөр 500 м² өвлийн хүлэмжийг байгуулсан,
- Төв аймагт 3 аж ахуйн нэгж 1.0 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 2400 м² хүлэмжийг,
- Хувийн хэвшлийн 4 аж ахуйн нэгж 6.4 тэрбум төгрөгөөр 11200 м² өвлийн хүлэмжийн аж ахуйг байгуулав.

Үүний үр дүнд хүлэмжийн ургацын хэмжээ 500 тонноор, талбайн хэмжээ 5.1 хувиар тус тус нэмэгдэх боломж бүрдлээ.

Мөн гадаадын төсөл, хөтөлбөрүүдтэй хамтран хөрөнгө оруулалт хийхээр ажиллаж байна.

Тухайлбал:

➤ УБ хотын иргэдийн хүнс, тэжээлийн аюулгүй байдлыг хангах зорилгоор "Ухаалаг хүлэмжийн аж ахуй, нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх" 7.0 сая ам.долларын төслийг 2021 оноос хэрэгжүүлэхээр Солонгосын хөдөөгийн хөгжлийн эдийн засгийн хүрээлэнтэй хамтран боловсруулж БНСУ-ын талд санал хүргүүлсэн,

➤ АНУ-аас хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэхэд зориулан 3.0 сая ам.долларын буцалтгүй тусламж үзүүлэхээр шийдвэрлээд байна.

Дүгнэлт: Төсөл тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа тул 70 хувиар үнэлэв.

6. “Алслагдсан орон нутагт сүүн бүтээгдэхүүнийг кластерын зарчмаар үйлдвэрлэж, импортыг орлож, экспортыг нэмэгдүүлэх” төсөл

“Монголын ээдэмцэрийн холбоо” ТББ-ын санаачлагаар “Алслагдсан орон нутагт сүүн бүтээгдэхүүнийг кластерийн зарчмаар үйлдвэрлэж, импортыг орлож, экспортыг нэмэгдүүлэх” төслийг боловсруулан ТЭЗҮ, байгаль орчны үнэлгээ хийлгүүлсэн. Төслийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр одоогоор шийдвэрлэгдээгүй байна.

Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд сүүн бүтээгдэхүүнийг кластерийн зарчмаар үйлдвэрлэх чиглэлээр дараахь ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Тухайлбал:

Сүү ХК санаачлан НҮБ-ын ХХААБ-ын санхүүжилтээр сүү бэлтгэн нийлүүлэгчдийг хоршоо болгон, хоршоо бүрийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, сүүний чанарыг сайжруулах, хөдөө аж ахуйн зохистой дадлыг хоршооны оролцогч бүр фермдээ нэвтрүүлэх, үйлдвэрт чанартай сүү нийлүүлэх зорилгоор орчин цагийн сүү бэлтгэн нийлүүлэлтийн анхны загвар хоршоог Сонгинохайрхан дүүргийн Ар гүнтийн аманд байгуулсан.

Энэхүү үйл ажиллагаанд 30 гаруй иргэн, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч оролцож сүү бэлтгэн нийлүүлэлт, сүүний чанар, сүүний гарцын талаар санал солилцсон, хоршоо нь тайлант онд 20.2 сая.литр түүхий сүү үйлдвэрт тушаасан байна.

Статистик үзүүлэлтээс харахад: Урьдчилсан байдлаар 2020 онд үйлдвэрийн аргаар 173.1 сая.литр сүү, сүүн бүтээгдэхүүнийг боловсруулсан бөгөөд өмнөх онтой харьцуулахад 5 хувиар өссөн үзүүлэлттэй гарахад төслийн үр нөлөө нөлөөлсөн гэж үзэж байна.

Булган аймгийн Булган суманд “Хатан мээж хайрхан” ХХК нь цагт 5тн хүчин чадал бүхий сүү боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулж, "Шинэ хөдөө Булган" төслөөр олгогдсон 17.0 сая төгрөг бүхий айраг хадгалах хөргүүрт чингэлэгийг Сайхан суманд хүлээлгэн өгч, 7 суманд 263.2 сая төгрөг бүхий 3 тоннын багтаамжтай сүү хадгалах ёмкост бүхий контейнер, тоног төхөөрөмж, 5 ширхэг 40 литрийн бидоны хамт хүлээлгэн өгсөн.

Дүгнэлт: Төсөл тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа тул 70 хувиар үнэлэв.

7. “Биокомбинат үйлдвэрийн өргөтгөл” төсөл.

Төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хийгдэх ёстой гэрээ хэлэлцээрүүд бүрэн хийгдэж УИХ-аар батлагдсан.

Гэрээний дагуу 2020 ондоо багтаан барилгын зураг, төслийг баталж, барилгын буулгалт, угсралтын ажлыг эхлүүлж 30 хувьд хүргэхээр тооцоолсон боловч, Ковид-19 цар тахлаас үүдэлтэй хатуу хөл хорионоос болж, төлөвлөгөөт ажлууд хойшлогдсон. Гэсэн ч төслийн хуваарьт өөрчлөлт оруулж, 2020 оны 12 дугаар сараас 2021 оны 01 дүгээр сар хүртэлх хугацаанд барилга буулгалтын ажлыг гүйцэтгэж, 04 дүгээр сараас барилга угсралтын ажлыг эхлүүлэхээр тохиролцсоны дагуу ажил явагдаж байна.

Дүгнэлт: Тухайн төслийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн тул уг төслийг “50” хувиар үнэлэв.

ДӨРӨВ. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

1. “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн хүнс, хөдөө аж ахуйн салбарт хамаарах төслийн 2020 оны хэрэгжилтийн ерөнхий дундаж “Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 57.1 хувиар үнэлэгдэж байна.

2. “Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих” төслийн хүрээнд тайлант онд

3. хийхээр төлөвлөсөн худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулж, нийлүүлэх техник, тоног төхөөрөмжийг 100 хувь хүлээж авч, иргэн, аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй зээлээр 12 жилийн хугацаанд олгосон нь бодит дэмжлэг болж, тус оноос эхлэн тариалалтын талбай, ургацын хэмжээ нэмэгдэж байгаа үр дүн гарч эхэлсэн байна.

4. “Дөрвөн улирлын хүлэмж” төслийн хүрээнд шинээр 14100 м² өвлийн хүлэмжийг байгуулсан, үүний үр дүнд хүлэмжийн ургацын хэмжээ 500 тонноор, талбайн хэмжээ 5.1 хувиар тус тус нэмэгдэх боломж бүрдсэн байна.

5. “Алслагдсан орон нутагт сүүн бүтээгдэхүүнийг кластерийн зарчмаар үйлдвэрлэж, импортыг орлож, экспортыг нэмэгдүүлэх” төслийн хүрээнд: Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд хөрөнгө оруулалт хийж, сүү бэлтгэн нийлүүлэгчдийг нэгтгэн хоршооны системд оруулснаар 20.2 сая литр сүүг үйлдвэрт тушаасан нь үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсөхөд нөлөөлсөн.

6. “Биокомбинат үйлдвэрийн өргөтгөл” төслийн “Санхүүгийн хамтын ажиллагааны ерөнхий хөтөлбөрийн тухай хэлэлцээр”-т оруулах нэмэлт өөрчлөлтийг УИХ-аар 2019.12.20-ны өдөр соёрхон баталсан. Гэрээний дагуу 2020 онд багтаан барилгын зураг, төслийг баталж, барилгын буулгалт, угсралтын ажлыг эхлүүлж 30 хувьд хүргэхээр тооцоолсон боловч, Ковид-19 цар тахлаас үүдэлтэй хатуу хөл хорионоос шалтгаалж, төлөвлөгөөт ажлууд хойшлогдсон. Төслийн хуваарьт өөрчлөлт оруулж, 2020 оны 12 дугаар сараас 2021 оны 01 дүгээр сар хүртэлх хугацаанд барилга буулгалтын ажлыг гүйцэтгэж, 04 дүгээр сараас барилга угсралтын ажлыг эхлүүлэхээр тохиролцсоны дагуу ажил хийгдэж байна.

7. “Махны үйлдвэр, хорио цээрийн бүс бүхий цогцолбор байгууламж барих техникийн шинэчлэл хийх”

8. төслийг хэрэгжүүлэх хүрээнд Монголын талаас ТЭЗҮ-ийн ажлын даалгаврыг боловсруулж БНХАУ-ын талд хүргүүлсэн. БНХАУ-ын “Машин механизм, аж үйлдвэрийн корпораци” (Sinoconst)-ийн боловсруулсан ТЭЗҮ нь тус яамнаас гаргасан ажлын даалгаврын шаардлагыг зарим талаар хангаагүй тул төслийн ажил удааширч, зогсонги байдалд орсон нь хөтөлбөрийн хэрэгжилтийг буурахад нөлөөлсөн.

9. Санхүүжилтийн асуудал шийдвэрлэгдэхгүйгээс “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтэц байгуулах” төслийн хэрэгжилт жил бүр хангалтгүй дүгнэгдэж байгаа нь хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ буурахад нөлөөлсөн.

10. УИХ-ын “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” 2020 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Монгол

Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”, УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тус тус ХХААХҮЯ-ны хамаарах асуудалд Эмээлтийн хөнгөн үйлдвэрлэл, технологийн парк, Налайхын барилгын материал үйлдвэрлэл технологийн паркийн дэд бүтцийн асуудал тусгагдаагүй байна.

11. ХХААХҮЯ-наас Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу “Дархан арьс ширний цогцолбор ҮТП, Шинэ Ховд ҮТП-ийг байгуулахаар төлөвлөгөө батлуулан, тодорхой ажлуудыг эхлүүлсэн тул дээрх үйлдвэрлэл технологийн паркийн чиглэлийг өөрчлөн, бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх эсэх асуудлыг Улаанбаатар хотын захирагчтай хамтран шийдвэрлэх шаардлагатай.

12. “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн явц удаашралтай байгаагийн гол шалтгаан нь хөрөнгө оруулалт, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхгүйгээс төслийн үйл ажиллагаа удаан хугацаанд зогсонги байдалд орж, анхны боловсруулж, тооцоолсон ТЭЗҮ судалгааг дахин боловсруулах, хугацаа алдах зэргээр зорилтот түвшин, хүрэх үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

1. Засгийн газрын 2019 оны 290 дүгээр тогтоолын 2-т заасан “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд болон хөрөнгө оруулалтаар тухайн жилд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосны дагуу төслийн санхүүжилтийн асуудлыг жил бүрийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлэхийг Бодлого, төлөвлөлтийн газар, Санхүү, хөрөнгө оруулалтын газар, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт,

2. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт ХХААХҮЯ-нд “Дархан арьс ширний цогцолбор ҮТП, Шинэ Ховд ҮТП-ийг байгуулахаар тусгагдсан тул “Эмээлтийн хөнгөн үйлдвэрлэл, технологийн парк”, “Налайхын барилгын материал үйлдвэрлэл технологийн парк”-ийн чиглэлийг өөрчлөн, бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх эсэх асуудлыг Улаанбаатар хотын захирагчтай хамтран шийдвэрлэхийг Бодлого, төлөвлөлтийн газарт, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт,

3. Төслийг хэрэгжүүлэгч газруудын хоорондын уялдаа холбоог сайжруулж, хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулж, үр дүнд хүргэх, тайланг хугацаанд нь хүргүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар, Гадаад хамтын ажиллагааны хэлтэст тус тус зөвлөж байна.